

**СҮХБААТАР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2024.10.04

Баруун-Урт сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Тус цагдаагийн газар нь энэ онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний сахилга, ёс зүйг төлөвшүүлэх, тэдний дунд албаны сургалт, соён гэгээрүүлэх ажлуудыг үе шаттай зохион байгуулж, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах, тасаг, хэсэг, алба хаагч бүрийн ажлын бүтээлч чанар, үр дүнг өмнөх оны мөн үеэс ахиулах зорилт дэвшүүлэн ажиллалаа.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан Цагдаагийн газрын энэ оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 35 заалттайгаар боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргаар баталгаажуулан, хэрэгжилтийг 3 дугаар байдлаар тооцож, цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 88.0 хувьтай дүгнэж, Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сүхбаатар аймгийг /2021-2025/ онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/, аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас гаргасан албан даалгавар, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг цахимаар тайлагнаж хэрэгжилтийг хангасан.

Тайлангийн хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын даргаас 12 үүрэг, 1 зөвлөмж, Тэргүүн дэд даргаас 35 үүрэг, ажлын чиглэл, 5 зөвлөмж, Дэд даргаас 26 үүрэг, ажлын чиглэл, 12 зөвлөмж, нийт 101 ирүүлснийг тухай бүрт нь нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, нотломж үйлдэн, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хугацаатай үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийн биелэлт, үр дүнг тооцож, холбогдох тасаг, хэсэгт заасан хугацаанд хүргүүлэн ажилласан.

Байгууллагын даргын зөвлөлийн хуралдааны талаар:

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар 2024 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг тасаг бүрээс санал авч нэгтгэн, нийт 18 ажил, арга хэмжээг хэлэлцэхээр баталж, 3 дугаар улиралд зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулан хуралдуулж, 14 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар үйл ажиллагааны талаар 2, хүний нөөц, шагнал урамшуулал олгох талаар талаар 7, сахилга хариуцлага, албаны шалгалтын талаар 4, нийт 14 асуудлын талаар хэлэлцэн, Цагдаагийн газрын даргын тушаалаар болон дээд газраар шийдвэрлүүлэхээр холбогдох албадад уламжлан шийдвэр гаргуулан ажилласан.

Энэ оны 3 дугаар улиралд Цагдаагийн газрын даргын А дугаартай тушаал 16, Б дугаартай тушаал 19, нийт 35 тушаал гарган хэрэгжилтийг нь хангаж ажилласан.

Хүний нөөцийн бодлогын талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/135 дугаар тушаалаар тус цагдаагийн газрын орон тоог офицер 71, ахлагч 42, гэрээт ахлагч 4, энгийн 2, нийт 119 орон тоотойгоор баталж, энэ оны 3-р улирлын байдлаар офицер 68, ахлагч 45 нийт 4 орон тоо дутуу /Хэсгийн төлөөлөгч 1, хэсгийн байцаагч 1, эрүүлжүүлэх байрны дарга, эмч 1, зохицуулагч 1/ ажиллаж байгаа нь хүний нөөцийн нөхөн хангалт 96.6 хувьтай байна.

Цагдаагийн газраас тайлангийн хугацаанд хэв журмын цагдаа, харуулын цагдаа, цагдаа жолооч, олон нийтийн цагдаа, эрүүлжүүлэх саатуулах байрны эмч болон сул орон тооны талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас, “Сүхбаатар аймгийн цагдаагийн газар” пейж хуудаст байршуулан, иргэдэд мэдээллийг хүргэж ажилласан ба энэ хугацаанд цагдаагийн байгууллагад ажиллах хүсэлт гаргасан 4 иргэнийг судалж, шалгалтад оруулж 2 иргэнийг суралцуулахаар 1 иргэнийг сул орон тоонд томилуулах саналыг хүргүүлэхээр бэлэн болгоод байна.

Алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн томилохдоо цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-909/ заасны дагуу албан тушаал дэвшүүлэх ерөнхий болон тусгай болзол, шаардлага хангаж буй эсэхийг Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж хэвшсэн ба офицер албан тушаалын нөөцөд бүртгэгдсэн тус цагдаагийн газарт шилжин ажиллах хүсэлт гаргасан 1 алба хаагчийг мэдээлэл судалгааны мэргэжилтнээр, ахлах албан тушаалын нөөцөд

бүртгэгдсэн 1 алба хаагчийг экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгчөөр дэвшүүлэн томилуулахаар санал, материалыг холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлээд байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Шагнал, урамшил олгох /код 925/” журам-ын дагуу Бүгд найрамдах улс тунхагласны 100 жилийн ойг тохиолдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар 4, Цагдаагийн ерөнхий газрын шагналаар нийт 8 алба хаагчийг шагнуулахаар хэлэлцэж, материалыг холбогдох алба, нэгжид уламжилж ажилласан.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-д заасан төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас эсхүл энэ хуулийн 16.1-д заасан удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс ...” гэж заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн цэргийн байгууллагын алба, нэгжүүдэд мэдээллийг 1 удаа хүргэж ажилласан. Ингэснээр тус цагдаагийн газрын сул орон тоонд Говь-Алтай аймгийн цагдаагийн газраас 1 алба хаагч шилжин ажиллах хүсэлт гаргасныг шийдвэрлүүлэхээр холбогдох газарт уламжлаад байна.

Алба хаагчдын мэдлэг боловсролын дээшлүүлэх чиглэлээр Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын эчнээ сургалтад 10, энгийн их дээд сургуульд 9 алба хаагчийг суралцуулж байна.

Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалтын үр дүнгийн талаар:

Цагдаагийн газраас 2024 онд алба хаагчдын дунд зохион байгуулах “Цагдаагийн газрын албаны сургалтын төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, алба хаагч, ажилчдад Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, мэдвэл зохих хууль тогтоомж, алба хаагчийг хөгжүүлэх, дадлагажуулах чиглэлээр танхимаар 49 сэдвээр 68 цагийн сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагууд сургагч багш нартай хамтран 7 хоног бүрийн “Пүрэв” гараг бүрт албаны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ оны 3 дугаар улиралд алба хаагчдад 5 удаагийн 7 цагийн сургалт зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 215 алба хаагч, ажилтныг хамруулсан.

Цагдаагийн газрын алба хаагчдын мэдлэг ур чадварыг сайжруулах, алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогт тохирсон сургалтыг зохион байгуулах зорилгоор тасаг, хэсгүүд дотооддоо долоо хоногт 1 удаа сургалт зохион байгуулахаар хуваарийг баталж хэрэгжилтийг ханган энэ оны 3 дугаар улиралд 12 удаагийн сургалтыг мөн Алба хаагчдыг танхимаар нэгдсэн журмаар биш ажлын байран дээр сургаж дадлагажуулах зорилгоор цагдаагийн газрын ёс журмын эргүүлийг үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад ажлын байранд зааж сургах, мэдээллээр хангах ажлыг батлагдсан хуваарь, сэдвийн жагсаалтын хүрээнд зохион байгуулж хэвшүүлсэн бөгөөд энэ оны 3 дугаар улиралд 38 удаа давхардсан тоогоор 1342 алба хаагчийг хамруулсан байна.

Соён гэгээрүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, үр дүнгийн талаар:

Энэ оны 3 дугаар улиралд цагдаагийн газрын алба хаагчдын дунд Спорт хамтлагаас “Дартс”, “Биллиард”, “Шатар”-ын тэмцээнийг зохион байгуулсан.

Цагдаагийн газрын алба хаагчдын харилцаа хандлагыг сайжруулах, хамт олонч нийтлэг уур амьсгалыг бүрдүүлэх, соёлч, боловсон алба хаагчдыг нэмэгдүүлэх зорилгоор Цагдаагийн газрын даргын санаачилсан “Өглөөний кофе” арга хэмжээг тасаг, нэгж бүрийг хуваарилсан хуваарийг дагуу өглөөний 07 цаг 30 минутаас 08 цаг 30 минутын хооронд зохион байгуулж байна. Уг арга хэмжээнд алба хаагчдад амьдралын зөв дадал хэвшлийн талаарх мэдээлэл өгөх, өөрийгөө одоогийн байдлаар хэрхэн тодорхойлох, цаашид хэрхэн зорилгоо зөв тодорхойлох талаар ярилцах хэлбэрээр зохион байгуулж байна.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар цэргийн алба хаасны тэтгэвэрт гарах хүсэлт гаргасан 4 алба хаагчийн материалыг бүрдүүлэн холбогдох албанд хүргүүлэн шийдвэрлүүлж, 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгуулсан.

Мөн аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй 5 жил ажилласан 4 алба хаагчид 30 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний урамшлыг нэг удаа олгуулсан.

Тус цагдаагийн газарт албаны 5 орон сууц байдаг бөгөөд орон нутагт томилогдож ирсэн алба хаагчдыг тухайн орон нутагт дасан зохицож, өөрийн гэсэн амьдрах байр, орон сууцтай болох хүртэлх хугацаанд байрлуулж, тогтвор суурьшилтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Сумдад томилогдон ажиллаж буй алба хаагч нар албаны цагдаагийн тасаг, хэсгийн байр /кобан/-нд амьдарч байгаа бөгөөд дээрх алба хаагчдын тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр чиглэлээр тухайн сумдын Засаг дарга нартай жил бүр “Гурвалсан гэрээ”-г байгуулан, үр дүнг тооцон ажиллаж байна.

Алба хаагчдаас Энэ оны 3 дугаар улирлын байдлаар 6 алба хаагч орон сууцны 6 хувийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтийг гаргаж, цагдаагийн газрын зүгээс шаардлагатай тодорхойлолт, бичиг баримтыг гаргаж өгсөн.

Алба хаагчдын сахилга, ёс зүйг сайжруулах, харилцаа хандлагыг нэмэгдүүлэх, сахилгын зөрчил үйлдэхэд сэтгэл зүйн ямар шалтгаан нөлөөлж байгааг тодорхойлох зорилгоор энэ оны 3 дугаар улирлын “Сахилгын зөвлөгөөн”-ийг “Сэтгэл зүйн зөвлөгөөн” хэлбэрээр анх удаа зохион байгууллаа. Зөвлөгөөний үеэр алба хаагчдад 3 дугаар улирлын сахилга ёс зүйн мэдээллийг хүргэж, зөрчил гаргасан алба хаагч өөрийн хүсэлтээр алба хаагчдад хандаж өөрийн сэтгэгдлээ илэрхийлсэн. Зөвлөгөөнд танхимаар 54, цахимаар 24, нийт 78 алба хаагч оролцож танхимаар оролцсон алба хаагчдыг 6 баг болгон хуваарилж, багийн гишүүн бүрийг үүрэг, хариуцлагатай байхаар бодож суудлын хуваарилалтыг хийсэн ба баг бүрт ахлагч, илтгэгч, дэг журам сахиулагч, цаг баригч, мэдээлэл цуглуулагч, няцаагч, бичээчийг баг дотор нь томилуулан оролцоог хангасан.

Сэтгэл зүйн зөвлөгөөн гэдэг утгаар алба хаагчдад тулгамдаж байдаг асуудлуудаар “Кейс анализ” хийлгэж ажилласан ба асуудлыг шинжилж, сэтгэл зүйн байдал нь алба хаагчдын сахилга ёс зүйн зөрчил гаргахад хэрхэн нөлөөлдөг талаар илтгэл тавьж зөвлөмж боловсруулан ажилласан. Мөн алба хаагчдын ажлын байранд шийдвэрлэхийг хүсдэг асуудлуудыг “Wish box” буюу хүслийн хайрцаг нэртэй санал хүсэлтийн хайрцаг аялуулж, алба хаагчдын “EQ” чадварыг нэмэгдүүлэхээр зөвлөмж бэлтгэж “Шүхэр” картаар дуусгаагүй өгүүлбэрийг гүйцээх дасгал ажиллуулж нийт алба хаагчдын мэдрэмжийг хуваалцсан.

“Today I feel” нэртэй ханын самбар гаргаж өнөөдөр би “Аз жаргалтай байна”, “Хөгжилтэй байна”, “Гайхсан байна”, “Уурласан байна”, “Уйтгарласан байна” гэсэн таван мэдрэмжийн хэсэгт өөрсдийн яг одоо мэдэрч байгаа байдлаа илэрхийлэн бичих боломжтой орчин бүрдүүлсэн бөгөөд энэ нь алба хаагч мэдрэмжээ гадагшлуулж тайвшрах, бусдад өөрийгөө ойлгуулах хэрэгцээ нь хангагдах ач холбогдолтой ажил болсон.

“Өдөр бүр өчигдрөөс илүү байя” аяны хүрээнд алба хаагч, удирдлагын хамтын ажиллагааг сайжруулах, алба хаагчдад тулгамдаж буй асуудлыг хөндөж гаргах, түүнийг шийдвэрлэх зорилгоор тус цагдаагийн газрын даргатай “Кофетой өглөө” өглөөний уулзалт, ярилцлагыг зохион байгуулж байна. “Кофетой өглөө” өглөөний уулзалт, ярилцлагыг тусгайлсан төлөвлөгөөний дагуу алба хаагчдын хийж хэрэгжүүлж буй ажлын онцлог, гүйцэтгэж буй үүрэг, хүйсийн ялгаагаар нь 8 хэсэгт хуваарьт оруулан, 7 хоногт 2 удаа уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлж байгаа ба одоогоор “Эмэгтэйчүүдийн зөвлөл”, “Захиргааны удирдлагын тасаг”, “Шуурхай удирдлагын тасаг”-ыг хүлээж авч уулзалт хийгээд байна. Уулзалтын үеэр нөөцийн карт ашиглан алба хаагчдын мэдрэмжийг гадагшлуулж, ажлын байрандаа өөрийгөө хэрхэн мэдэрч байдаг талаар ярилцан, тэдний санаа бодлыг сонсон, шийдвэрлэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулах журмын хэрэгжилтийг хангах, Цагдаагийн Ерөнхий газраас зохион байгуулж буй “**Өдөр бүр өчигдрөөс илүү байя**” аяны салбар төлөвлөгөөг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор энэ оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгууллага дээр нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгт 84 аж ахуй нэгж, албан байгууллагын төлөөллийг оролцуулж, Цагдаагийн газрын энэ оны эхний 9 сард хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, “Ногоон бүс” камержуулалтын явцын талаарх танилцуулан иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, хариу өгөх, иргэдэд нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Цахим залилангаас сэргийлье зурагт хуудас сэрэмжлүүлгийг тарааж, 9 дүгээр сарын байдлаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг танилцуулсан. Мөн 200 иргэнээс цагдаагийн газрын үйл ажиллагаа болон алба хаагчдын харилцаа хандлагын чиглэлээр “Санал асуулга”-ын хуудсаар саналыг авч дүнг нэгтгэн ажиллаж байна. Тухайн арга хэмжээнд оролцсон 30 иргэний дунд “Хийн буудлага”-ын тэмцээнийг зохион байгуулж, шилдгүүдийг шалгаруулсан.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар:

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор тус цагдаагийн газрын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 66, шинээр томилогдсон болон албан тушаал өөрчлөгдсөн 21 алба хаагчаар ХАСХОМ-ийг цахимаар хуулийн хугацаанд гаргуулах ажлыг зохион байгуулж, баталгаа, тайлан мэдээ, баталгааны хуудсыг Дотоод хяналт-Аюулгүй байдлын газарт хүргүүлсэн.

Цагдаагийн газрын “Сүхбаатарын аймгийн цагдаагийн газар” цахим хуудсанд “Авлигаас ангид байгууллага” зурагт хуудсыг тогтмол байршуулж сурталчлан, авлига, ашиг сонирхлын зөрчил, алба хаагчтай холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах 126, ЗГ-ын 1111 дугаарын утас болон цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгийн жижүүрийн 7051102, 88772102 дугаарын утсаар хүлээн авч ажилласан ба цагдаагийн газрын алба хаагчдаас энэ оны байдлаар авлига, хээл хахууль авах, өгөх, зуучлах, шан харамж авах гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй.

Цагдаагийн газрын иргэдийг хүлээн авах хэсэгт иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар цагдаагийн газарт хандах самбарыг байршуулж, самбарт гомдол мэдээллийг хүлээн авах, шалгаж

шийдвэрлэх, өргөдөл гомдол гаргах загварыг болон цагдаагийн газрын удирдах албан тушаалтнуудын утасны жагсаалтыг гарган байршуулсан.

Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар:

Цагдаагийн газрын удирдлага, албан тушаалтанд хандаж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 211 өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч, бүртгэн, холбогдох албан тушаалтан шалгаж шийдвэрлэн хуулийн хугацаанд хариу өгсөн. Ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг ангилж үзвэл: Ажилд орох, суралцахыг хүссэн 23, ажилд дахин орохыг хүссэн 1, ажлын байр өөрчлөх, шилжих, чөлөөлөгдөхийг хүссэн 29, захиргааны чөлөө хүссэн 79, тэтгэвэр, тэтгэмж орон сууц хүссэн 16, бусад 52, үлдэгдэл 1 байна.

Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх, тэдний үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавих зорилгоор “Цагдаагийн газрын дотоод журам”-д заасны дагуу тасгийн дарга, ахлах албан тушаалтнуудыг хуваарьт оруулан “Ёс журам сахиулах эргүүл”-ийн үүргийг 24 цагаар гүйцэтгүүлэн ажиллаж үр дүнг тогтмол тооцож байна.

Ёс журам сахиулах эргүүлийн илтгэх хуудаст зөрчил заагдсан алба хаагчдыг 7 хоног бүр зөрчлийн бүртгэлд нэгтгэн бүртгэж, зөрчил заагдсан алба хаагчийг тус цагдаагийн газрын “Сахилга ёс зүйн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэн алба хаагчдаас дахин зөрчил гаргахгүй талаар баталгаа авч, зохих хариуцлагыг тооцон ажиллаж байна.

Тус цагдаагийн газрын алба хаагчдаас энэ оны 3 дугаар улиралд 5 алба хаагч сахилгын арга хэмжээ /офицер 5 / авагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. Сахилга, ёс зүйн зөрчлийн хэлбэрээр авч үзвэл ажлын хариуцлага алдсан 4, ажил тасалсан 1 байна. Шийтгэлийн төрлийг авч үзвэл 4 алба хаагчид сануулах, 1 алба хаагчид албан тушаалын сарын үндсэн цалинг 10-20 хүртэл хувиар бууруулах арга хэмжээ ногдуулсан.

Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Сангийн яамнаас 2024 оны байдлаар урсгал үйл ажиллагааны санхүүжилт 3,645.7 сая төгрөгийн төсөвтэйгөөс энэ оны 3 дугаар улиралд 1,500.0 сая буюу 40.5 хувийн гүйцэтгэлтэй, нэмэлт санхүүжилтийн харилцахад 139,351.150 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар 116 алба хаагчдын 401.977.709.1 төгрөгийн цалин бодогдохтой холбогдуулан цалингаас 19.040.964 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 85.681.558 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг ноогдуулж, байгууллагаас 506.700.231 төгрөгийг нийгмийн даатгалын тайланг суутгаж харьяа байгууллагад шилжүүлэн ажилласан. Мөн 38 алба хаагчийн 131,166,324 төгрөгийн ээлжийн амралтыг бодож, баталгаажуулан олгосон. Олон нийтийн цагдаагийн 11 алба хаагчийн 33,000,000 сая төгрөгийн цалингийн гүйлгээний эрхийн хүсэлтийг төрийн сангаар баталгаажуулан эрхийг нээлгэж, 11 алба хаагчдад 33000,000 сая төгрөгийн цалинг бодож, эрхийн бүртгэлийн сангаар баталгаажуулан монгол банкаар дамжуулан олгосон.

3 дугаар улирлын байдлаар анхан шатны баримтуудыг үндэслэн 45,150,180 төгрөгийн бараа материалын /аж ахуйн материал, шатахуун, сэлбэг хэрэгсэл, барилгын материал, бичиг хэргийн материал болон хангамжийн материал/ орлогыг анхан шатны материалыг үндэслэн санхүүгийн программ шивж, анхан шатны баримтыг үндэслэн зарлагыг хийж, өглөг авлагыг хаасан.

Албаны авто машины норм лимитийг Зам, тээврийн хөгжлийн яамны сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/99 дүгээр тушаал “Шатахуун зарцуулалт, сэлбэг материалын ашиглалтын норм батлах тухай” хавсралтыг тус тус үндэслэн албаны автомашины баталсан нормын дагуу олгож ажиллаж байна.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар Дизель түлш 750.28 л, Ай-92 шатахуун 15.201 л, нийт 35,406,200 төгрөгийн шатахууныг 1, 2 дугаар гарын үсгээр баталгаажуулан олгосон.

ЦЕГ-ын Санхүү, ар талын албанаас Киарио автомашин шилжүүлэн авч байгууллагын данс бүртгэлд тусгасан. Хууль зүй дотоод хэргийн яамны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 1 ширхэг драгер 3.069.000, 1 тандагч 1.360.000, энгэрийн камер 5 ширхэг 1.732.000 орлогод авч, хариу мэдэгдлийг хүргүүлэн ажилласан.

Байгууллагын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгө болон авто тээврийн хэрэгслийн судалгааг гаргаж, ЦЕГ-ын Санхүү, ар талын албанд хүргүүлж, даатгуулсан. Албаны бэлэн байдлыг хангахад 3 тээврийн хэрэгсэлд 1,320,000 төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч, засвар үйлчилгээ хийсэн.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 2 алба хаагчдад 250,000 төгрөгийн албан томилолтыг олгосон. Мөн 116 алба хаагчдыг 33,800,100 төгрөгөөр 10-40 хүртэл хувиар үндсэн цалинг нэмж урамшуулсан.

Хоногийн хугацаанд цагдаагийн газрын жижүүрийн бүрэлдэхүүнд 24 цагаар үүрэг гүйцэтгэсэн 26 алба хаагчдын хоолны зардалд энэ оны 03 дугаар улирлын байдлаар нийт 10,400,00 төгрөг зарцуулж, алба хаагчдад халуун, хоол цайгаар үйлчилсэн.

Үнэт цаасны болон бусад тооцооны талаар: Үнэт цаасны тооцоог төвийн офицер, цагдаа нартай өдөр тутам, хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай сар тутам тооцоо нийлж, энэ оны 3 дугаар улирлын сард алба хаагч нарт дарга, нягтлан бодогчийн цохолтоор 56 алба хаагчид 139 ширхэг шийтгэлийн хуудас олгогдсон. Үүнээс маягт-1-аар 21 алба хаагчид 24 ш, маягт-2-оор 35 алба хаагчид 115 ширхэг олгосон.

Шилэн дансны ил тод байдлыг хангах талаар: Цагдаагийн газраас Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 118 мэдээллийг хуулийн хугацаанд шивж, 100 хувийн гүйцэтгэлтэй байршуулсан.

Тус цагдаагийн газар 2024 онд түлш, тослох шатах материал 118,493.4 төгрөгийн төсөв батлагдсан. Түлш, шатах тослох материал худалдан авах ажиллагааны тендерийн төлөвлөгөөг <https://user.tender.gov.mn/> цахим дээр шивж цахимд тендерийг нээж ажилласан. Одоогоор Петровис” ХХК-тай хамтран ажиллаж байна.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Эрүү, хэв журмын нөхцөл байдал:

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, илрүүлэх чиглэлээр энэ оны 3 дугаар улирлын байдлаар тус цагдаагийн газарт иргэд, байгууллагаас 2242 гомдол, мэдээлэл ирүүлснээс 786 буюу 35,7 хувийг гэмт хэргийн, 1456 буюу 64,3 хувийг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байна.

Урьд оны мөн үеийнхтэй харьцуулбал нийт гомдол мэдээлэл 76 нэгжээр буюу 3.2 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол 74 нэгжээр буюу 4.8 хувиар буурсан, гэмт хэргийн шинжтэй гомдол 2 нэгжээр буюу 0.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд 369 гэмт хэрэг бүртгэгдэж, урьд оны мөн үеэс 4 нэгжээр буюу 1.1 хувиар буурсан байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 369 буюу 51.7 хувийг хөнгөн, 90 буюу 44,4 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байна. Гэмт хэргийн илрүүлэлт 50.3 хувьтай буюу урьд оны мөн үеийнхээс 5.8 хувиар өссөн. Энэ оны 3 дугаар улирлын байдлаар 21018 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4512 нэгжээр буюу 21.4 хувиар өссөн.

Зөрчлийн шинжтэй хүлээн авсан 1450 гомдлоос 828 гомдолд зөрчлийн хэрэг нээж, 487 гомдлыг хялбаршуулсан журмаар шалгаж, 124 гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна. Зөрчлийн шийдвэрлэлтийг авч үзвэл 20322 иргэн, хуулийн этгээдийг 797.406.000 төгрөгөөр, 392 иргэний жолоодох эрхийг хасаж 156.800.000 төгрөгөөр тус тус торгож, 214 иргэнийг шүүхээр баривчлуулсан байна.

Урьд оны мөн үеийнхтэй харьцуулбал торгосон хүн 4550 буюу 22,3 хувиар, мөнгөн дүн 60.301.000 төгрөг буюу 7.5 хувиар өссөн, баривчлагдсан хүн 214 буюу өмнөх оны мөн үетэй 23 нэгжээр буюу 9.7 буурсан. Нийт зөрчлийн 891 буюу 64.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 135 буюу 9.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 355 буюу 25.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

Энэ оны 3 дугаар улиралд тус тасгаас гэмт хэрэгтэй тэмцэх, нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, үйлдэгдсэн гэмт хэргийн талаар мэдээ мэдээлэл цуглуулах, гэмт хэргийн илрүүлэлтийн түвшинг ахиулах, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлтийг хувийг нэмэгдүүлэх, эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр хариуцсан нутагт “Эко-2024”, “Устгал-2024”, “Цохолт”, “Байгалиа хамгаалъя-2024” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцож ажилласан байна.

Тус тасгийн алба хаагчид энэ 3 дугаар улиралд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн 261 гомдол, мэдээлэл хүлээн авснаас зөрчлийн шинжтэй 90 гомдол, мэдээлэл гэмт хэргийн шинжтэй 171 гомдол мэдээлэл хүлээн авснаас 64 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, 15 гомдлыг гомдлоос эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан, 52 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 1 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлсэн, хуулийн хугацаанд 47 гомдлыг шалгаж байна. Урьд оны хэрэг бүртгэлтийн 197 хэргийн үлдэгдэлтэй, энэ оны 3 дугаар улирлын байдлаар хэрэг бүртгэлтийн 66 хэрэг шинээр нээж, нийт 132 хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 58 хэргийг нөхөн илрүүлж, 19 хэргийг хааж, 1 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 1 хэргийг нэгтгэж илрүүлэлтийн хувь 50.3 хувьтай байна.

Эрэн сурвалжлах чиглэлээр: Энэ оны 3 дугаар байдлаар Сураггүй алга болсон хүн 18 зарлаж 18 олж тогтоон үлдэгдэл 0, Оргодол 10 зарлаж 8 олж тогтоон үлдэгдэл 2, Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 128 зарлаж 104 олж тогтоон үлдэгдэл 24, Цогцос 1 зарлаж 1 хэн болохыг тогтоож үлдэгдэл 0, Галт зэвсэг, сум хэрэгсэл 0 зарлаж 0 олж тогтоон үлдэгдэл 0, Түүх соёлын дурсгалт, үнэт зүйлс 0 зарлаж 0 олж тогтоон үлдэгдэл 0, Хулгайлагдсан тээврийн хэрэгсэл 2 зарлаж 2 олж тогтоон үлдэгдэл 0, Бодис 0 зарлаж 0 олж тогтоон үлдэгдэл 0, Мал амьтан 2 зарлаж 1 олж тогтоон

үлдэгдэл 1, Эд зүйл 1 зарлаж 0 олж тогтоон үлдэгдэл 1, Аман зураг 0 зарлаж 0 олж тогтоон үлдэгдэл 0, Шүүхээс даалгасан хүн 16 зарлаж 11 олж тогтоон үлдэгдэл 5, Зөрчил үйлдсэн этгээд 16 зарлаж 14 олж тогтоон үлдэгдэл 2, нийт 200 хүн, мал, эд зүйл эрэн сурвалжлалт зарлаж, 179 олж тогтоосон нь илрүүлэлт 89.5 хувьтай байна.

Эдийн засгийн албаны чиглэлээр: Эдийн засгийн албаны чиглэлээр: Эдийн засгийн мөрдөгч 2024 оны 3 улиралд иргэд, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 16 гомдол, мэдээлэл хүлээн авч 6 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, 10 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн байна. Хэрэг бүртгэлтийн 22 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 2 хэргийг илрүүлж, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан, үлдэгдэл 20 хэрэг байна.

Экологийн албаны чиглэлээр: Экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Гантулга нь энэ оны 3 дугаар улиралд иргэд, байгууллагаас хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн 2, бусад гэмт хэргийн шинжтэй 12 гомдол, мэдээлэл хүлээн авч 1 гомдлыг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан. 10 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай, 3 гомдлыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байна. Зөрчлийн шинжтэй 1 тооны гомдол мэдээлэл илрүүлэн холбогдох байгууллагад шилжүүлж ажилласан.

Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчдаас илрүүлсэн онцлог гэмт хэргээс дурдвал:

- Өмнөговь аймгийн Даланзадгад 5 дугаар баг Зүүнсайхан 4 гудамж, 26 тоот оршин суух хаягтай, урьд ял шийтгэл эдэлж байгаагүй Нямаагийн Отгон, Өмнөговь аймгийн Даланзадгад 5 дугаар баг Зүүнсайхан 4 гудамж, 24 тоотод оршин суух хаягтай, урьд ял шийтгэл эдэлж байгаагүй Нямаагийн Отгонбаяр, Өмнөговь аймгийн Номгон сумын 4 дүгээр баг, Эмгэнбулаг гэх газар оршин суух хаягтай, урьд ял шийтгэл эдэлж байгаагүй Заандэлгэрийн Өсөхзаяа нартай байнга холбоотой бүлэг бөөгнөрөл үүсгэдэг. Энэ хугацаанд бүлэглэлээс хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэгт холбогдон шалгагдаж шүүхэд шилжсэн.

- “Майн-Тех” мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн эрх бүхий албан тушаалтнууд бусадтай хамтран 2021-2022 оны хичээлийн жилд суралцаагүй сурагчдын ирцийг бүртгэж, бүртгэгдсэн суралцагч бүрээс сар бүр олгодог тэтгэлгийн 200,000 төгрөгнөөс нь 150,000 төгрөгийг нь хувьдаа завшиж нийт 36,635,000 төгрөгийн хохирол учруулсан гэх эрүүгийн 243000043.0248 дугаартай хэрэгт Т.Амартүвшин, Ө.Тайвансанаа, Г.Амарзаяа нарыг яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлсэн.

- Дорнод аймгийн Хэрлэн сум 6 дугаар баг Өнөр 23 дугаар байрны 49 тоотод оршин суух Санжаагийн Галсан /жү77102672/ нь 2024 оны 07 дугаар сарын 22-ны шөнө 01 цагийн үед Дорнод аймгаас Улаанбаатар хот руу Истана маркийн 48-33 УНП улсын дугаартай тээврийн хэрэгслээр их хэмжээний дэрэвгэр, жиргэрүүг өвсийг тээвэрлэж явсан гэх Хэрэг бүртгэлтийн 243000249 хэрэг нээн холбогдох ажиллагааг хийж ажиллаж байна.

- 2024 оны 05, 06 дугаар сард Сүхбаатар аймгийн Асгат сумын 3 дугаар баг Хужиртын голоос түгээмэл тархацтай ашигт малтмал болох хайрга олборлосон гэх хэрэг бүртгэлтийн 243000234 тоот хэрэг нээн холбогдох ажиллагааг хийж байна.

- Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 7 дугаар багийн иргэн А.Жаргалсайхан /лм60012051/ нь 2021 оны 11 дүгээр сарын 12-ний өдөр тус аймгийн Эрдэнэцагаан сумын 7 дугаар багт байхдаа Эрдэнэцагаан сумын зүс таних хүмүүст 10.000.000 төгрөг зээлсэн боловч тухайн хүмүүст өгсөн мөнгөө буцаан авч чадахгүй залилуулсан гэх хэрэг бүртгэлтийн 223000367 дугаартай хэргийг Эрдэнэцагаан сумын 3 дугаар багийн иргэн Төмөрбаатар овогтой Болортуяа /лм76011701/, Пүрэв овогтой Баасанбаяр /лм75110212/ нар нь бүлэглэн үйлдэж бусдад 10.000.000 /арван сая/ төгрөгийн хохирол учруулсан хэргийг яллагдагчаар татаж 2024 оны 09 дүгээр сарын 23-ний өдөр эрүүгийн 2230003670253 дугаартай хэрэг нээн мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн.

- 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Баруун-Урт сумын 8 дугаар баг Төмөртэйн 1-3 тоотод оршин суух иргэн Баатар овогтой Баянмөнх /ЛЮ68042210/, 3 дугаар баг чулуутын 17-6 тоотод оршин суух иргэн Наянтай овогтой Анхболд /ЛА78070410/, 8 дугаар баг тээвэрчдийн 312 тоотод оршин суух Мажигсүрэн овогтой Мөнх-Очир /ЛЮ79082170/, 2 дугаар баг уртын 1100 тоотод оршин суух Сүхбаатар овогтой Эрдэнэтөгс /ЛЮ88100570/, 2 дугаар баг тээвэрчдийн 7-2 тоотод оршин суух иргэн Моононшар овогтой Ганболд /ЛЛ81110172/ нар нь улсын дугааргүй Даюун, супер даюун, Jian Ying маркийн улсын дугааргүй мотоциклтой 14 тооны зээрийг зөвшөөрөлгүй агнасныг илрүүлэн холбогдох ажиллагааг хийж харьяаллын дагуу Байгаль орчин аялал жуулчлалын газарт шилжүүлж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны даргын энэ оны 06 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Байгаль хамгаалал-2024” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах, хүний шууд болон шууд бус нөлөөллийн улмаас байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг бууруулах, улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон аялал жуулчлалын бус, усны сав түүний нөөц газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас үүссэн ахуйн болон аюултай хог хаягдал, бусад төрлийн бохирдлоос сэргийлэх, хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалах, байгаль орчны тэнцэл алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 3 ажил, 12 арга хэмжээ зохион байгуулах салбар төлөвлөгөөг боловсруулан аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, цагдаагийн газрын дарга нараар батлуулан биелэлт, үр дүнг тооцон ажиллахад биелэлт 94 хувьтай дүгнэгдсэн.

2024 оны 09 дүгээр сарын 05-ний өдөр Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын баталсан “Эко-2024” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах. Экологийн цагдаагийн албаны 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.2 дахь хэсэгт “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулж, үр дүнг тооцох гэж төлөвлөгдсөний дагуу Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шийдвэрлэлтийг ахиулах, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийг хяналтад авах зорилгоор 4 ажил, 18 арга хэмжээ зохион байгуулах салбар төлөвлөгөөг боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулан биелэлт, үр дүнг тооцон ажиллалаа.

Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар нийт 268 гомдол мэдээлэл хүлээн авч шалган үүнээс 82 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 73 гомдлыг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 6 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 94 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, нийт 255 гомдол мэдээллийг шийдвэрлэж, одоо ажиллагаанд 13 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Хэрэг бүртгэлтийн хэрэг: 2024 оны 3 дугаар улирлын байдлаар урьд оны үлдэгдэл 16 хэрэг дээр шинээр 137 хэрэг хүлээн авч, нийт 153 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас 75 хэргийг хаах саналтай, 6 хэргийг харьяаллаар шилжүүлэх саналтай шилжүүлж, 1 хэргийг нэгтгэж, 40 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан, нийт 122 хэргийг шийдвэрлэж, одоо ажиллагаанд 31 хэргийн үлдэгдэлтэй байна.

Мөрдөн байцаалтын хэрэг: 2024 оны 3 дугаар улирлын урьд оны үлдэгдэл 22 хэрэг дээр, шинээр 255, шүүхээс буцсан 3 хэрэг тус тус хүлээн авч нийт мөрдөн байцаалтын 280 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 46 хэргийг нэгтгэж, 221 хэргийг шүүхэд шилжүүлэх, 2 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай тус тус прокурорт шилжүүлж, нийт 269 хэрэг шийдвэрлэж, одоо ажиллагаанд 8 хэргийн үлдэгдэлтэй байна.

Энэ 3 дугаар улирлын нийт шалгасан мөрдөн байцаалтын хэргийн 96.1 хувийг шийдвэрлэсэн, мөн 3 хэрэгт хугацаа сунгасан нь нийт шалгасан мөрдөн байцаалтын хэргийн 1.4 хувийг эзэлж байгаа нь Мөрдөн байцаах албаны шалгуур үзүүлэлтийг хангасан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд нийт 366.9 сая төгрөгийн хохирол учирснаас 311.7 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 84.9 хувьтай байна.

Түдгэлзүүлсэн хэрэг: 2024 оны 3 дугаар улирлын байдлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг байхгүй.

Цагдан хориотой этгээд: Энэ оны 3 дугаар улирлын байдлаар 8 яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, хэргийг үндсэн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр: Шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн 221 хэрэгт гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай 221 мэдэгдэл бичиж, холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдаас зөрчлийн шинжтэй 105 гомдол мэдээлэл хүлээн авч 63 гомдолд зөрчлийн хэрэг нээж, 17 гомдлыг хялбаршуулсан журмаар шалгаж, 16 гомдлыг хүлээн авахаас татгалзаж, 4 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэсэн. Зөрчил гаргасан 1275 иргэнийг 32,450,000 /гучин хоёр сая дөрвөн зуун тавин мянга/ төгрөгөөр, шийтгэлийн хуудсаар 77 иргэнийг 9,355,000 /есөн сая гурван зуун тавин мянга/ төгрөгөөр торгож арга хэмжээ тооцсон, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 8, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 4 зөрчлийг тус тус илрүүлэн ажилласан.

Урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын чиглэлээр: Баруун-Урт суманд эргүүлийн нэгдсэн байршилтыг 3 чиглэлд 5 алба хаагч, 3 олон нийтийн цагдаа, 2 автомашинтай өдөр тутам, сумдад 1 эргүүлийн чиглэлд 24 алба хаагч, 5 олон нийтийн цагдаа, 10 автомашинтай томилон ажиллуулж, тасгийн дарга, ахлах албан тушаалтан ёс журмын эргүүл өдөр тутмын хяналт тавьж, үүрэг ажлын чиглэл өгч биелэлтийг хангуулан ажилласан.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор давхардсан тоогоор 354 аж ахуйн нэгж, байгууллага /төрийн байгууллага 86, төрийн бус байгууллага 45, байгууллага, ахуйн нэгж 175/-ийн харуул хамгаалалтыг нэгдсэн байдлаар 24 удаа, эргүүлийн чиглэлд тухай бүр шалгаж илэрсэн зөрчлийг засуулах, мэдэгдэл, зөвлөмж өгч ажилласан.

Аймаг орон нутгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан “Ногоон бүс”, “Хичээл эхэллээ” зэрэг 2 арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцсон.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга сурталчилгааны ажлыг 18 удаа зохион байгуулж, гарын авлага, зурагт хуудас 68, санамж, сэрэмжлүүлэг 62, нийт 130 ширхэг тарааж, давхардсан тоогоор 28 аж ахуйн нэгж, байгууллагын 197 иргэн хамрагдсан.

Эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагааны чиглэлээр: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсоны улмаас хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан нийт 45, энэ байдлаас болж өөрөө осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчилд холбогдон саатуулагдсан 243 хүнд эмчийн үзлэг хийн эрүүлжүүлэх, саатуулах байранд хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн.

Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шийтгэх тогтоолын дагуу баривчлах шийтгэл хүлээсэн 166 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлах байранд хүлээн авч, шүүхийн шийтгэх тогтоолын биелэлтийг хангасан.

Эрүүлжүүлэгдсэн болон баривчлагдсан 247 иргэнээс 6,850,000 / зургаан сая найман зуун тавин мянган/ төгрөгийн төлбөрийг төрийн сангийн 100120012001 тоот дансанд төвлөрүүлж, санхүүгийн албатай тухай бүр тулгалт тооцоог хийж ажилласан.

Баривчлах байранд хүлээн авсан 247 хүнд албадан сургалтын төлөвлөгөө, хуваарийн дагуу дагуу “Архины хор уршиг”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архиан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль” “Зам тээврийн осол” “Хувь хүн ба гэр бүлийн харилцаа” зэрэг сэдвүүдээр эрх зүйн анхан шатны мэдлэгтэй болон, архины асуудлаа шийдвэрлэхэд нь туслах амьдрах ухаан өөртөө итгэх, итгэл үнэмшилтэй болгох зорилгоор нөлөөллийн чанартай сургалт яриа таниулга хийж, санамж зөвлөмж тарааж материалжуулан ажиллаж байна.

Архины хор уршиг, хөнөөлийг сурталчлан таниулах зорилго бүхий “Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар”, “Насан туршийн боловсрол”, “Мандах нар”, АА-гийн бүлэгтэй хамтран мөн хариуцсан алба хаагчид батлагдсан төлөвлөгөө хуваарийн дагуу баривчлагдсан иргэдийг 7 хоног өдөр бүр сургалтад хамруулж ажилласнаар 1 иргэн архинаас татгалзаж тус бүлэгт элссэн эерэг үр дүн гарсан.

Шүүхээр баривчлагдсан иргэдийн зан үйлд нөлөөлөх сургалтыг чанаржуулах, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар”, “Насан туршийн боловсролын төв”, “Мандах нар”, АА бүлгэм зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан согтууруулах ундааны хор уршиг, хөнөөлийг таниулах, татгалзуулах зорилгоор холбогдох хууль эрх зүйн актуудаар давхардсан тоогоор 265 удаагийн лекц, видео, асуулт хариулт хэлбэрээр зохион байгуулсан.

Баривчлах байранд хүмүүжигч нарт хууль эрх зүй, гарын авлага, мэдээлэл, танин мэдэхүйн 35 ширхэг ном, шторк, хэвлэлийн материалыг давхардсан тоогоор 240 удаа ном уншуулсан.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд эрүүл ахуй ариун цэврийг сахих зорилгоор ариутгалын бодис, халдвар хамгааллын хэрэгслийн нөөцийг сар бүр хүрэлцэхүйц хэмжээгээр бэлтгэн болзошгүй халдвараас урьдчилан сэргийлэн өдөр 2 удаа цэвэрлэгээ, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээ хийн ажиллаж байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын талаар:

Монгол банкны Сүхбаатар аймаг дахь салбарын хамгаалалтын гэрээг шинэчлэн баталгаажуулж гэрээний дагуу 4 алба хаагчийг томилон ажиллуулснаар, гэрээний үүрэгтэй холбоотой зөрчил дутагдал заагдаагүй.

Тус тасгаас гурав дугаар улирлын байдлаар аймгийн нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт 6 удаагийн хамгаалалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 148 алба хаагч, 34 цагийн үүрэг гүйцэтгэж ажилласан байна. Үүнд:

- Аймгийн баяр наадмын хамгаалалт зохицуулалт 45 алба хаагч 2 удаа 28 цагийн хамгаалалт.
- Сүхбаатар сумын түүхт 100 жилийн ойн хамгаалалт 19 алба хаагч 3 удаа 48 цагийн хамгаалалт;
- Төрийн албаны ерөнхий шалгалтын үеэр 2 удаа 16 цагийн хамгаалалт;
- Эрдэнэцагаан сумын түүхт 100 жилийн ойн хамгаалалт зохицуулалт 20 алба хаагч 3 удаа 41 цагийн хамгаалалт.
- Уулбаян сумын түүхт 100 жилийн ойн хамгаалалт зохицуулалт 19 алба хаагч 3 удаа 32 цаг хамгаалалт хийсэн.
- Хатиган хошууны баяр наадмын хамгаалалт зохицуулалтад 10 алба хаагч 2 удаа 16 цагийн хамгаалалт.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажлын талаар:

Тус цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасагт шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ахлах байцаагч 1, шүүх хуралдааны дэг сахиулагч хамгаалалтын цагдаа 1, харуулын цагдаа 4, нийт 6 алба хаагчийн орон тоотой Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Хууль зүй дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/116/65 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах журам”, “Яллагдагч шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, ялтныг эрэн сурвалжлах ажиллагаа явуулах журам” болон бусад хууль, тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Сүхбаатар аймаг дахь Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүх, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Иргэний хэргийн анхан шатны шүүх, Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2024 оны 09 дүгээр сарын байдлаар Шүүхийн байрны А-Б шүүх хуралдааны 2 танхимд товтой болон товгүй нийт 368 шүүх хуралд журамд заасны дагуу шүүх хуралдааны дэг сахиулж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, бусад оролцогчдын аюулгүй байдлыг хангаж ажиллалаа. Үүнд:

- ❖ Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 909 оролцогчтой, 129 эрүүгийн хэргийн шүүх хурал, 891 оролцогчтой 231 зөрчлийн шүүх хурал, Эрүүгийн болон зөрчлийн нийт 1800 оролцогчтой, 360 шүүх хурал,
- ❖ Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 28 оролцогчтой 6 шүүх хурал,
- ❖ Давж заалдах шатны шүүхэд 186 оролцогчтой, Эрүүгийн 15, Зөрчлийн хэргийн 2 шүүх хурал тус тус явагдаж 2014 оролцогчтой, нийт 383 шүүх хуралдаанд журмын дагуу дэг сахиулж, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, бусад оролцогчийн аюулгүй байдлыг ханган ажилласан.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий харуул, хамгаалалтын цагдаа нар нь тус цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгийн хоногийн жижүүрт үүрэг гүйцэтгэж буй албаны тээврийн хэрэгслээр Шүүхийн байрнаас Цагдан хорих байранд 35 удаа, Цагдан хорих байрнаас шүүхэд 21 удаа, давхардсан тоогоор нийт 56 тооны яллагдагч, шүүгдэгч, ялтанг, мөн зөрчил үйлдэн шүүхээр баривчлагдсан 210 этгээдийг тус аймгийн цагдаагийн газрын “Баривчлах байр”-нд тус тус хуяглан хүргэх ажиллагаа явуулж, журамд заасны дагуу аюулгүй байдлыг ханган, “Цагдан хорих байр”-ны ээлжийн дарга болон “Баривчлах байр”-ны эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.

Тус цагдаагийн газрын алсын дуудлагад ашиглаж байсан Лада маркийн 31-21 сүз улсын дугаартай тээврийн хэрэгслийг цагдан хорих, шүүхэд хуяглан хүргэх үйл ажиллагаанд ашиглах талаар цагдаагийн газрын даргатай зөвшилцөн, урсгал засварт шаардлагатай зардлыг шүүхийн тамгын цагсаар шийдвэрлүүлж, үйл ажиллагаанд ашиглаж байна.

Шүүхийн харуул, хамгаалалтад харуулын цагдаа 24 цагаар 4 ээлжээр үүрэг гүйцэтгэх хугацаанд шүүх хуралдааны оролцогч, шүүхээр үйлчлүүлсэн нийт 9095 иргэний бичиг баримтыг шалгаж, бүртгэн, шүүх хуралд оролцогчдын бие, эд зүйлд үзлэг хийн, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, шүүхийн байр, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, бусад оролцогчдын аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Шүүхийн харуулын болон хамгаалалтын цагдаа нарын өдөр тутмын үүрэг гүйцэтгэлт, шүүхийн байранд нэвтэрч байгаа иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих, мөн шүүхийн байрны аюулгүй байдлыг хангаж тухайн өдрийн жижүүрийн офицер, ёс журам сахиулах эргүүл болон өөрийн биеэр биечлэн хяналт тавин ажиллахад шүүхийн байранд гарсан зөрчил дутагдалгүй.

Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирээгүй яллагдагч, шүүгдэгч, хэргийн оролцогч, зохигч, зөрчлийн холбогдогч, иргэний хариуцагчийг шүүхэд албадан ирүүлэх 14 тооны захирамж хүлээн авч, 14 этгээдийг заагдсан хугацаанд шүүхэд албадан ирүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч, захирамжийн биелэлтийг хангаж ажилласан.

Одоо албадан ирүүлэх захирамжийн биелэлт хангах ажиллагааг явуулж байгаа нэг байна.

2024 оны 09 дүгээр сарын байдлаар тус аймаг дахь Эрүүгийн болон Иргэний хэргийн анхан шатны шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас оршин суух хаяг, хаана байгаа нь тодорхойгүй үндэслэлээр эрэн сурвалжлах 25 шүүгчийн захирамж, шийдвэр хүлээн авч, Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “АСАП” санд бүртгэн, улсын хэмжээнд эрэн сурвалжлалт зарлаж 19 этгээдийг оршин суух хаяг тогтоох, биеэр олж авах зэрэг ажиллагаа явуулж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч эрэн сурвалжлах зогсоож шийдвэрлэсэн.

Одоогоор урьд оны үлдэгдэл Шүүхээс эрэн сурвалжлагдаж байсан 2, энэ оны 1 этгээд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас эрэн сурвалжлагдаж байгаа 3 хариуцагч нийт 6 этгээдийг оршин суух хаягийг олж тогтоох, албадан ирүүлэх эрэн сурвалжлах ажиллагааг явуулж байна.

Мөн шүүхийн байрны гадна талын аюулгүй байдлыг хангах хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох зорилгоор аймгийн Газрын харилцаа, Барилга, Хот байгуулалтын газарт албан тоот хүргүүлж, кадастрын зураг гаргуулан, уг зургийн дагуу шүүхийн байрны гадна хамгаалалтын бүсийг тогтоож Шүүхийн байрны гадна хамгаалалтын бүсийг тогтоосон 50 метр дотор байгаа айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж материалжуулсан.

Харуулын цагдаагаар шинээр томилогдсон цагдаагийн дэд ахлагч Б.Ганбаатар, Б.Отгонбаатар, Б.Ганбат нар томилогдож, шинээр томилогдсон алба хаагчийг ажилд нь богино хугацаанд сурган, дадлагажуулах зорилгоор цагдаагийн даргын тушаалаар дадлагажуулагч багш томилуулан, холбогдох хууль, журмыг судлуулан, өдөр тутмын үйл ажиллагаанд нь биечлэн хяналт тавьж ажиллаж байна.

Шүүхийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахдаа Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсээс ирүүлсэн ажлын үүрэг, зөвлөмж, чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан байна.

Замын цагдаагийн тасгийн чиглэлээр:

Аймгийн хэмжээнд 2024 оны 3 дугаар улиралд замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 16, зам тээврийн осол 37, нийт 53 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэнээс гэмт хэргийн улмаас нас барсан хүн 3 /зорчигч-1 жолооч-2/ хүнд болон хүндэвтэр гэмтэл /жолооч-2, зорчигч-3/ явган зорчигч 5 байна.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Баруун-Урт сумын Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нараар Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 1,2,3,4 дүгээр сургуулиудын явган хүний гарцанд байршуулах “Явган хүний лед гэрлэн гарц”-ны 50.000.000 /тавин сая/ төгрөгийг шийдвэрлүүлж, Биеийн тамир спортын газрын 4-н замын уулзвар, ЕБ-ийн 1,2,3,4 дүгээр сургуулийн гарц, номин худалдааны төвийн 4-н замын уулзвар дээр Явган хүний лед гэрлэн гарцыг байршуулсан.

Тус тасгийн алба хаагчид батлагдсан хуваарийн дагуу гудамж замд болон орон нутгийн чанартай авто замын хяналт шалгалтаар ажиллахдаа нийт 6420 зөрчил илрүүлснээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 113, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй буюу тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 21 зөрчлийг тус тус илрүүлж, Зөрчлийн тухай хуульд зааснаар бэлэн бус торгуулийн төхөөрөмжөөр замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, холбогдох дүрэм, журам зөрчсөн 5977 жолоочид 151.155.000 төгрөгийн торгууль оногдуулж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 92 жолоочийг Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1,2,3 дахь хэсэгт заасны дагуу зөрчлийн хэрэг нээж Сүхбаатар аймаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлснээс 13 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан болон эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 44 хүнийг 17.600.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.

Зам тээврийн осол, хэрэг зөрчлийн шинжтэй дуудлага мэдээлэл 53 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 7.01 хувиар буурсан байна. Хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 16 бүртгэгдсэн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр буюу 5.8 хувиар буурсан, осол хэргийн улмаас нас барсан 1 нэгжээр 33.3 хувиар өссөн бөгөөд ослын улмаас гэмтсэн хүн 2 нэгжээр буюу 14.2 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн ослын шалтгаан нөхцөлийг судлахад согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоноос, замын нөхцөлд хурдаа тохируулаагүйн улмаас, зогсоох арга хэмжээ аваагүй улмаас, ухрах үйлдэл хийхдээ зэрэг шалтгааны улмаас нь үйлдэгдсэн байна. Үйлдэгдсэн ослын 30 буюу 58.8 хувь нь суурин газарт, хөдөө орон нутгийн замд 21 буюу 41.2 хувь нь үйлдэгдсэн байна.

“Шугам зам, хар цэг” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн BBS телевизтэй хамтран зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр замын цагдаагийн тасгийн зохицуулагч, Цагдаагийн дэслэгч Б.Бямбажав мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.

“Амь аврах алтан гурвалжин” арга хэмжээний хүрээнд аймгийн BBS телевизтэй хамтран зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, Цагдаагийн ахлах дэслэгч Д.Батчулуун мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.

Төгс авто засвартай “Гэрэл” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй замын хөдөлгөөнд оролцож байгаа 50-н тээврийн хэрэгслийн гэрлийг үнэ төлбөргүй сольж мөн зөрчил дутагдалгүй замын хөдөлгөөнд оролцож байгаа 3-н жолоочид тус авто засварын гарын бэлэг өгч хамтран ажилласан.

Тээврийн цагдаагийн албанаас ирүүлсэн “Зуны зугаатай аялал” 1000ш сэтгүүлийг Баруун-Уртаас Мөнххаан чиглэлийн А2001 авто замд хөдөлгөөнд оролцож байгаа жолоо, иргэдэд тарааж ажилласан.

“Шугам зам хар хэсэг” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд аймгийн BBS телевиз, Suhkbaatar.info сайттай хамтран зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр замын цагдаагийн тасгийн зохицуулагч, цагдаагийн дэслэгч А.Ганхолбоо орон нутгийн замд тээврийн хэрэгслийн хурдны хэтрүүлэхгүй, суудлын хамгаалах бүс хэрэглэх, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй замын хөдөлгөөнд оролцохгүй байх, холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлэх, замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх талаар мэдээ мэдээллийг хүргэсэн.

Мөн 2024-2025 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулж эцэг эх, асран хамгаалагчдад анхааруулга болох зорилгоор бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд харгалзах хүнгүйгээр

оролцуулах байх талаар яриа таниулга хийж Suhkbaatar.info сайттай хамтран иргэд олон нийтэд хүргэж ажилласан.

Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, оношилгоо хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Авто тээврийн төвтэй хамтарч байцаагч Б.Чогдонгийн хамт Улсын чанартай А2001 авто замд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж бүрэн бус тээврийн хэрэгсэл болон үзлэг оношилгоонд оруулаагүй тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцож явсан 546 жолоочид 14.790.000 төгрөгийн арга хэмжээ тооцож газар дээр арилгах боломжтой 56 тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулж, замын хөдөлгөөнд соёлтой оролцох талаар яриа таниулга хийн 1500 ширхэг санамжийг тараан ажилласан.

Тээврийн цагдаагийн албанаас ирүүлсэн “Явган хүний гарцаар гарахдаа хүүхдүүдээ, ахлах болон дунд ангийн сурагчид зам хөндлөн гарахдаа хэрэгжүүлэх 7 зөвлөмж” сэдэвтэй контентыг Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 1,2,3,4 дүгээр сургууль, Эрдэнэцагаан, Мөнххаан, Түмэнцогт сумдын ерөнхий боловсролын сургуулиудын пэйж хуудсан байршуулан сурагч, иргэдэд хүргэсэн. Мөн уг контентыг BBS телевиз, Suhkbaatar.info сайтын пэйж хуудсанд байршуулан иргэд олон нийтэд хүргэж ажилласан.

Онхолдох хэлбэрийн зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийн талаар Suhkbaatar.info сайттай хамтран 50 секундйн видео шторк бэлтгэн Сүхбаатар аймгийн цагдаагийн газрын пэйж хуудсанд байршуулан тасгийн алба хаагч нараар олон дагагчтай групп-д шэйр хийлгэж мэдээ мэдээллийг хүргэсэн.

Замын цагдаагийн тасгийн зохицуулагч, Цагдаагийн ахлах дэслэгч А.Ганхолбоо Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн Б.Мөнхзул багштай 8Б ангийн 32 сурагчдад сурон, унадаг дугуй, скүүтер, мопед унаж замын хөдөлгөөнд оролцохгүй байх бага насны хүүхэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт орсон.

Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, Цагдаагийн дэслэгч С.Сайнбилэг Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн Б.Мөнхзул багштай 8Б ангийн 32 сурагчдад сурон, унадаг дугуй, скүүтер, мопед унаж замын хөдөлгөөнд оролцохгүй байх бага насны хүүхэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт орсон.

Тээврийн цагдаагийн албанаас ирүүлсэн Ерөнхий боловсролын 1,2,3,4-дүгээр сургуулийн “school Police” үүрэг гүйцэтгэж байгаа эцэг, эх, асран хамгаалагч нарт зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Баруун-Урт сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж зөрчил дутагдлыг газар дээр нь засаж янзалсан. Баруун-Урт- Өндөрхаан чиглэлийн А2001 дугаартай авто замын эвдрэл болон тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж 45 зөрчил илрүүлж ажилласан.

Талын зам орон нутгийн өмчит компани, Хот тохижилт ОНӨҮГ-уудад тэмдэг, тэмдэглэгээ, замын эвдрэлийг янзлах талаар мэдэгдэл хүргүүлсэн

Баруун-Урт сумын 6 дугаар баг Бурхантай хөшөөний урд талын явган хүний 4 тэмдэг, явган хүний анхааруулах тэмдэг 4 ширхгийг хураан авсан. Эрчмийн 4-н зам дээр байсан байршил заасан 7 тэмдгийг хураан авсан.

Сүхбаатар аймаг Баруун-Урт сумын Талын зам ТӨМХ-нд Баруун-Урт- Өндөрхаан чиглэлийн А2001 дугаартай автозамын эвдрэлийг засаж янзлах талаар албан мэдэгдэл хүргүүлсэн.

2024-2025 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан Баруун-Урт сумын авто замын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж зөрчил дутагдлыг газар дээр нь засварласан. Баруун-Урт сум Өндөрхаан сумын чиглэлийн Улсын чанартай А2001 дугаартай авто замын эвдрэл болон тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулахаар “Талын зам” орон нутгийн өмчит компани, Сүхбаатар тохижилт ОНӨААТҮГ-т тэмдэг, тэмдэглэгээ, замын эвдрэлийг засварлаж биелэлтийн танилцуулгыг тус тасагт ирүүлэх талаар 3 заалт бүхий 46,47 дугаартай албан мэдэгдлийг энэ оны 08 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Баруун-Урт сумын 3 дугаар баг ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн урд талын авто замын явган хүний тэмдэглэгээ, тус 5 дугаар баг сургуулийн өмнөх 4 дүгээр цэцэрлэгийн зүүн талын авто замын явган хүний тэмдэглэгээ, аймгийн нэгдсэн эмнэлгийн хойд талын авто замын зорчих хэсгийн тусгаарлах тэмдэглэгээг сэргээн засварласан.

Баруун-Урт суманд хийгдэж байгаа авто зам болон бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан зам замын байгууламж сэтэлж гарц гарам гарах ажлын хэсгийн хуралд энэ оны 08 дугаар сарын 15, 23-ны өдрүүдэд 3 удаа сууж уг асуудлыг шийдвэрлэсэн.

Гудамж замын хяналт шалгалтаар 6098 зөрчил илрүүлж 11634600 төгрөгөөр, тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоонд оруулаагүй 381 жолоочид Зөрчлийн тухай хуулийн 14.7-10.2 дахь заалтаар 19.500.000 төгрөгөөр, 14.6.5 дахь заалтаар 225 жолоочид 4.500.000 төгрөгөөр, 14.7.15 дахь заалтаар 1055 жолоочид 21.100.000 төгрөгөөр тус тус арга хэмжээ авч ажилласан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 122 жолоочид Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1-т зааснаар тус бүр 400.000 төгрөгөөр торгож, жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, Цагдаагийн ерөнхий газрын TPS программд эрх хасалтыг оруулж шийдвэрлэсэн.

2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд “Талын тээвэр”, “Хорол жолоо”, “Эм жи моторс”, “Хос мөр”, “БХТН” “Бэнчин” “Шаргын хүлэг” авто сургуулиудын 291 сонсогчоос замын хөдөлгөөний дүрмийн болон жолоодлогын шалгалтыг авч, В ангиллын шалгалтад 140 тэнцсэн, ангилал ахиулах шалгалтад 111 суралцагчаас тэнцсэн 75 нийт 215 иргэний холбогдох материалыг Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвд хүргүүлсэн.

Монгол Улсын хууль зүй дотоод хэргийн сайдын А/142 тоот тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх журам”-ын дагуу тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа “Уран авто зам”, “Үе цэгээн” НҮТББ авто сургуулийн “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх” сургалтад хамрагдсан нэр бүхий 132, нийт 87 иргэний материалыг хянаж үзээд албан тоотоор хүргүүлсэн.

2024 оны 07 дугаар сарын 26, 27, 28-ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн Уулбаян, Эрдэнэцагаан, Сүхбаатар сум үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмын 6 насны хурдан морьны хамгаалалт болон замын хөдөлгөөнд аюулгүй байдлыг хангах чиглэлээр Замын цагдаагийн алба хаагч нар хөдөлгөөн зохицуулах, хяналт шалгалт, наадмын талбайн авто замыг хаах, мөн орох үеийн зохицуулалт хамгаалалт хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зөрчил дутагдалгүй ажилласан.

Сүхбаатар аймгийн “Шилийн богд” мото клуб, аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Шилийн богд” мото фестивалийн арга хэмжээ 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Баруун-Урт сумын Надмын талбайд зохион байгуулагдаж Замын цагдаагийн 7 алба хаагч хөдөлгөөн зохицуулах, хяналт шалгалт, наадмын талбайн авто замыг хаах, мөн орох үеийн зохицуулалт хамгаалалт хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зөрчил дутагдалгүй ажилласан.

Сүхбаатар аймгийн Баруун-урт сумын засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн” 100м болон 500 метрийн гүйлтийн хамгаалтанд 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр замын цагдаагийн тасгийн алба хаагч нар хөдөлгөөн зохицуулах үеийн хамгаалалтыг хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зөрчил дутагдалгүй ажилласан.

Сүхбаатар аймгийн Баруун-урт суманд зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааны хамгаалтанд 2024 оны 09 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд замын цагдаагийн тасгийн алба хаагч нар хөдөлгөөн зохицуулах, хяналт шалгалт, Сүхбаатарын талбайн авто замыг хаах, мөн орох үеийн зохицуулалт хамгаалалт хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зөрчил дутагдалгүй ажилласан.

Пара олимпийн мөнгөн медаль-т МУГТ хөдөлмөрийн баатар Г.Болорэрдэнэ нутагтай ирэх болон буцах үеийн хамгаалтанд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр замын цагдаагийн тасгийн алба хаагч нар хөдөлгөөн зохицуулах, хяналт шалгалт, Сүхбаатарын талбайн авто замыг хаах, мөн орох үеийн зохицуулалт хамгаалалт хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зөрчил дутагдалгүй ажилласан.

Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан “Эрүүл монгол хүн үндэсний хөдөлгөөн” бүх нийтийн гүйлтийн хамгаалтанд 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулагдаж замын цагдаагийн тасгийн алба хаагч нар хөдөлгөөн зохицуулах Сүхбаатарын талбайн авто замыг хаах зохицуулалт хамгаалалт хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зөрчил дутагдалгүй ажилласан.

Улсын хэмжээнд “Машингүй өдөр” арга хэмжээний хүрээнд Сүхбаатар аймгийн Баруун-урт сумын нэгдүгээр тойргийн авто замыг замын цагдаагийн тасгийн алба хаагч нар хааж хөдөлгөөн зохицуулаж хамгаалалт хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зөрчил дутагдалгүй ажилласан.

Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан “Унадаг дугуйн” хамгаалтанд 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж замын цагдаагийн тасгийн алба хаагч нар хөдөлгөөн зохицуулах Сүхбаатарын талбайн авто замыг хаах зохицуулалт хамгаалалт хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зөрчил дутагдалгүй ажилласан.

Шуурхай удирдлагын тасгийн чиглэлээр:

Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн газрын конторын нэг, хоёр, гурав дугаар давхар, эрүүлжүүлэх байрыг теле хяналтын камераар тогтмол хяналт тавьж ажилласан байна. Цагдаагийн байгууллагын хамгаалалтад байгаа Шүүх, Монгол банкны харуулын цагдаа нартай 2 цаг тутам утсаар болон станцаар холбогдон хяналт тавьж, тухай бүрд нь үүрэг, чиглэл өгч, ажлын бус цагаар нэвтэрч байгаа иргэд, алба хаагчдыг пролоор нэвтрүүлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллажээ.

Цагдаагийн газрын Жижүүрийн шуурхай албанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн нийт 782 дуудлага, мэдээллийг хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 271, зөрчлийн шинжтэй 383, бусад 128 дуудлага мэдээллийг “Од программд” бүрэн оруулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан.

Дуудлага мэдээллийн “ECS” программд гэмт хэргийн шинжтэй 271, зөрчлийн шинжтэй 383 нийт 654 гомдол, мэдээлэл оруулж, тухай бүрд нь хянасан төлөвт авч, тасгийн дарга цохолт хийснээр гомдол, мэдээлэл орхигдуулаагүй ажилласан байна.

Тайлангийн хугацаанд цагдаагийн газрын дарга, дэд дарга, удирдах дарга нарт орой 21:00, өглөө 08:00 цагт тухай өдөр бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн гомдол, мэдээллийг танилцуулан удирдлагуудыг мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.

Ноцтой гэмт хэргийн талаарх 19 дуудлага, мэдээлэл ирснийг Цагдаагийн газрын Тэргүүн дэд дарга болон Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Онцгой нөхцөл байдлын шуурхай, удирдлага зохицуулалтын ажил хариуцсан нэгжид мэдээллийг хүргүүлэн чиглэл авч ажилласан.

Энэ оны 3 дугаар улиралд тус цагдаагийн газрын баривчлах байранд баривчлагдсан 66 иргэнд тогтмол хяналт тавьж, эрүүлжүүлэх саатуулах байранд саатуулагдсан зөрчлийн холбогдогч 8 иргэн, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ биеэ авч явах чадваргүй 2 иргэнийг Аймгийн нэгдсэн эмнэлгийн Яаралтай түргэн тусламжийн тасагт /103/ үзүүлэн эрүүлжүүлэх байранд хүлээн авч хяналт тавин ажилласан.

Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор тус цагдаагийн газрын үүдний коридор хэсэгт байрлуулсан телевизээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчилсан видео, шторк, гэмт хэрэг, зөрчлийн статистик тоон мэдээллийг тогтмол явуулж байна.

“Ногоон бүс” арга хэмжээний хүрээнд- Тус цагдаагийн газраас камержуулалтын “Ногоон бүс” төслийн хүрээнд 2023 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 350.000.000 /гурван зуун тавин сая/ төгрөгөөр “Камерын хяналтын нэгдсэн төв”-ийг цагдаагийн газарт байгуулсан.

Аймгийн Засаг дарга М.Идэрбат, Баруун-Урт сумын Засаг дарга Ж.Жавхаатөгс нарт /камерын хяналтын төвийг хүлээн авч бүрэн бүтэн байдал, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр/ энэ оны 09 дүгээр сарын 17 өдөр албан бичгээр хүсэлт хүргүүлснээр 2023 онд цагдаагийн газарт байгуулсан “Камерын хяналтын нэгдсэн төв”-ийн эд зүйлс, техник хэрэгслийг Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын өмчлөлд энэ оны 09 дүгээр сарын 18-ны өдөр шилжүүлж, хүлээлгэн өгсөн.

“Ногоон бүс” төслийн хүрээнд 2024 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сум, багуудын нутаг дэвсгэрийг бүрэн камержуулах, хяналтын нэгдсэн системд холбох ажлын санал, танилцуулгыг аймаг, сумдын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд албан бичгээр хүргүүлснээр Баруун-Урт сум 600.000.000 /зургаан зуун сая/ төгрөг, Мөнххаан сум 90.000.000 /ерэн сая/ төгрөг, Сүхбаатар сум 140.000.000 /нэг зуун дөчин сая/ төгрөг, Онгон сум 110.000.000 /нэг зуун арван сая/ төгрөгийг тус тус улсын төсөвт тусгуулж шийдвэрлүүлсэн.

Баруун-Урт сумын тойрог замын системийн орох, гарах 9 гарц дээр дугаар танигчтай тусгай зориулалтын 27 ширхэг камер суурилуулахад шилэн кабел татах, цахилгааны эх үүсвэр, цаашлаад багууд дээр тавигдсан камер болон иргэн, аж ахуйн нэгжүүдийн камерыг “Хяналтын нэгдсэн төв”-д холбох дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхээр зураг төслийн “Ар бэл Алтай” ХХК-иар ажлын зургийг гаргуулж, зураг төслийг Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвд магадлалд оруулахаар хүргүүлсэн. Барилгын хөгжлийн төвийн “Магадлалын ерөнхий дүгнэлт”-ийг энэ оны 10 дугаар сарын 03-ны өдрийн дотор гаргуулахаар тохиролцсон. Ингэснээр 10 дугаар сарын 15-ны дотор тендер зарлагдана.

Мөнххаан сумдын зураг төслийн “Уран тод цэг” ХХК-иар камержуулалтын ажлын зургийг гүйцэтгүүлж “Магадлалын ерөнхий дүгнэлт” гаргуулахаар зургийг энэ оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.

Онгон сум зураг төслийн “Зенит соолор” ХХК-иар камержуулалтын ажлын зургийг гүйцэтгүүлж дууссан бөгөөд энэ оны 09 дүгээр сарын 27-ны өдөр “Магадлалын ерөнхий дүгнэлт” гаргуулахаар зургийг Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвд хүргүүлэхэд бэлэн болоод байна.

Сүхбаатар сум зураг төслийн “Сод ажюу нум” ХХК-д захиалга өгч камержуулалтын ажлын зургийг гүйцэтгүүлж байна.

“Камерын хяналтын нэгдсэн төв”-ийг аймгийн Засаг даргын дэргэдэх “Нийтлэг үйлчилгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлчилгээний газарт харьяалуулж, хяналтын төвийг тохижуулах, урсгал засварын зардал, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулан ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын аюулгүй байдал, хэвийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, арчлан хамгаалах, хүний нөөц, цалин хөлс болон бусад зардлыг 2025 оны орон нутгийн төсөвт тусгахаар шийдвэрлэсэн.

Аймгийн Засаг даргын энэ оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/420 дугаар “Төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбайг хянах, стандартын шаардлагад нийцсэн камер суурилуулж, хяналтын нэгдсэн төвд холбох” тухай захирамж гаргуулсан.

Ногоон бүс” арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн энэ оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталсан сум, багийг камержуулах төлөвлөгөөнд энэ оны 3 дугаар улиралд тус аймгийн Асгат, Эрдэнэцагаан сум, Баруун-Урт сумын 1 дүгээр багийн Аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн камержуулахаар тусгасан.

Төлөвлөгөөний дагуу Асгат суманд 12 ширхэг камер, Эрдэнэцагаан суманд 14 ширхэг камер, Баруун-Урт сумын 1 дүгээр багт 47 ширхэг камер шинээр суурилуулахаар төлөвлөснөөс өнөөдрийн байдлаар Асгат суманд 12, Баруун-Урт суманд 30 нийт 42 ширхэг хяналтын камер суурилуулсан бөгөөд хэвийн ажиллаж байна. Камержуулалт 57.5 хувьтай явагдаж байна.

Баруун-Урт сумын 2, 3, 4, 5, 6, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 179 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг камержуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын энэ оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/420 дугаар Захирамж, цагдаагийн газрын албан мэдэгдлийг хүргүүлсэн.

“Хяналтын камер ажиллаж байна-Аюулгүй бүс” нэртэй гэрэл ойлгогчтой 60х40 хэмжээтэй “Теле камерын анхааруулга”-ын 60 ширхэг тэмдгийг “Товгор үсэг” ХХК-д захиалга өгч хэвлүүлэн аймгийн төвийн 60 цагт 60 ширхэг тэмдэг байрлуулсан.

Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн чиглэлээр:

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар иргэд, хуулийн этгээдээс 174 гомдол, мэдээлэл хүлээн авч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан ба 20 гомдол, мэдээллийг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 88 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 3 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 31 гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэн, одоо ажиллагаанд 32 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Зөрчлийн 88 хэрэгт Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулснаас 2 хэргийг хэрэгсэхгүй болгож, 27 хэргийн холбогдогч 27 иргэнийг эрх бүхий албан тушаалтан 3.240.000 төгрөгөөр торгож шийдвэрлэн, 86 хэрэгт шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авхуулах саналтай шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлж, одоо ажиллагаанд 22 хэргийн үлдэгдэлтэй байна. Зөрчил үйлдсэн 103 иргэнийг шүүхийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, 55 иргэнийг 5.620.000 төгрөгөөр торгож арга хэмжээ тооцон ажиллажээ.

Бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй зөрчлийн хэрэг байхгүй.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар шийдвэрлэсэн зөрчлийн хэрэгт Прокурорын газраас нэмэлт ажиллагаа хийлгүүлэхээр буцаасан хэрэг байхгүй. Мөн шалгалтын явц байдал удааширсан зөрчлийн хэрэг байхгүй.

Тус цагдаагийн газрын зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад гаргаж байгаа алдаа дутагдлыг арилгуулах, дахин зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж 2, зааварчилга 12, үүрэг ажлын чиглэл 3-ыг бичиж, цагдаагийн газрын даргад танилцуулан алба хаагчдад хүргүүлэн, биелэлтийг тухай бүр нь тооцсон.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр:

Сүхбаатар аймгийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хуралд 1, аймгийн Засаг даргад 1, Баруун-Урт сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 4, нийт 6 танилцуулга хүргүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд 6.5 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Аймгийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын танилцуулгыг 14 хоног тутам аймгийн удирдах ажилтны уулзалт, зөвлөгөөнд танилцуулж, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг сар бүр Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Баруун-Урт сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нарт хүргүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн газраас энэ оны 3 дугаар улирлын байдлаар 720.325.500 төгрөгийн торгууль ногдуулснаас 484.192.458 төгрөгийн торгуулийн мөнгөн дүнг төсөвт тушаалгасан байна.

Тус цагдаагийн газраас энэ оны 3 дугаар улирлын байдлаар тодорхой төрлийн гэмт хэргийг бууруулах зорилготой нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил 6.5 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлсэн.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газар болон бусад албадаас улсын хэмжээнд зохион байгуулсан “Урьдчилан сэргийлэх ажил-3”, “Анзаар”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлье”, “Шугаман эргүүл”, “Хамгаалах бүс”, “Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал”, “Оношилгоо”, “Жендерийн тэгш байдал”, “Хүүхдийг эрсдэлээс сэргийлье”, “Хичээл эхэллээ”, зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэртээ үр дүнтэй зохион байгуулж, дүн мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

Камержуулалтын “Ногоон бүс” төслийн хүрээнд аймгийн Засаг даргаар энэ оны 07 дугаар сарын 19-ний өдөр А/420 дугаартай “Төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбайг хянах, стандартын шаардлагад нийцсэн камер суурилуулж, хяналтын нэгдсэн төвд холбох” тухай захирамж гаргуулсан.

Цагдаагийн ерөнхий газраас нутаг дэвсгэрийг бүрэн камержуулж, камерын хяналттай “Ногоон бүс” болгох “Нэг хороо, нэг баг, нэг сум” дэд төслийн хүрээнд гаргасан хуваарийн дагуу Баруун-Урт сумын 1 дүгээр баг, Эрдэнэцагаан, Асгат сумдын 65 аж ахуйн нэгж, байгууллагад аймгийн Засаг даргын захирамж, цагдаагийн газрын албан мэдэгдэл, стандартад нийцсэн камер суурилуулахад шаардлагатай техникийн үзүүлэлт, жишиг үнийн судалгаа зэргийг хүргүүлж, 40 ширхэг камерыг 13.0 сая төгрөгийн өртгөөр шинээр суурилуулаад байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу аймгийн төв Баруун-Урт суманд 10, бусад сумдад 14, нийт 24 олон нийтийн цагдаагийн орон тоотойгоос өнгөрсөн 03 дугаар сард 14 олон нийтийн ажилласан бөгөөд олон нийтийн цагдаагийн сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Гэмт хэрэг, зөрчлийн хамгаалалтад 12 алба хаагч 16 удаа, зөрчил үйлдсэн 72 этгээдийг цагдаагийн байгууллага болон алба хаагчид хүлээлгэн өгч, 46 гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг мэдээлж холбогдох албан тушаалтанд бүртгүүлж, 286 зөрчлийг илрүүлж, холбогдох албан тушаалтнаар хуулийн дагуу арга хэмжээ тооцуулж, 36 аж ахуйн нэгж, байгууллагын 306 иргэнд бие даан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ухуулга яриа, сургалт зохион байгуулж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бичсэн 26 мөрдөгчийн мэдэгдэл, эрх бүхий албан тушаалтны шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцож, хариуг хугацаанд нь авсан байна.

Энэ оны 3 дугаар улиралд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн байгууллага 123, төрийн бус байгууллага 4, аж ахуйн нэгж 210-н харуул хамгаалалтыг 2 удаа шалгаж, үүрэг чиглэл өгч ажилласан. Одоогоор аймгийн хэмжээнд иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар байгуулагдсан “Малчдын бүлэг” 12, “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэм 17, “Хамтарсан баг” 22, “Сургуулийн эргүүл” бүхий сургууль 16 байна. Эдгээр баг, бүлгүүдийн 434 гишүүнд 14 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Тус цагдаагийн газрын хяналтад захиргааны хяналтад 12 иргэн /бүгд хэсгийн мөрдөгч нарын хяналтад/ байгаа бөгөөд хяналтад байгаа иргэдтэй сар бүр уулзан, гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх ухуулга, яриа, сургалт зохион байгуулж ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг 52, уулзалт, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн 1 зохион байгуулж, 136 байгууллага, аж ахуйн нэгж, сургууль цэцэрлэг оролцож, 2009 иргэн хамрагдсан.

Эрх бүхий алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар байгууллага, албан тушаалтанд 95 мэдэгдэл бичиж, 90 мэдэгдлийн хариу авч, 87 мэдэгдлийн мөрөөр хяналт шалгалтыг зохион байгуулсан ба 5 мэдэгдлийн хариу ирэх хуулийн хугацаа болоогүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг орон нутгийн “BBS” телевизээр 10 удаа, Sbinfo мэдээллийн цахим сайтад 10 удаа яриа өгч, мэдээлэл нийтлүүлсэн.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ажил, арга хэмжээ, гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөл, хор уршгийн талаарх мэдээллийг цахим орчинд иргэдэд сонирхолтой хэлбэрээр, шуурхай хүргэх, тэдний санал, хүсэлтийг сонсох зорилгоор 17000 дагагчтай “Сүхбаатар аймгийн цагдаагийн газар” пэйж, “Suhbaatar.police.gov.mn” цахим хуудсыг хөтөлж байна.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар “Сүхбаатар аймгийн цагдаагийн газар” пэйж хаягт 93 удаа мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг байршуулж, тус аймгийн олон дагагчтай группүүдэд түгээж, иргэд, олон нийтэд хүргэсэнээр 52352 хүний хандалт авч, 19074 удаа цааш олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг постер 19 төрлийг бэлтгэн 4000 ширхгийг иргэдэд тараасан.

ДҮГНЭЛТ:

1. Аймгийн хэмжээнд 369 гэмт хэрэг бүртгэгдэж, урьд оны мөн үеэс 4 нэгжээр буюу 1.1 хувиар буурсан байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 369 буюу 51.7 хувийг хөнгөн, 90 буюу 44,4 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байна. Гэмт хэргийн илрүүлэлт 50.3 хувьтай буюу урьд оны мөн үеийнхээс 5.8 хувиар өссөн. Энэ оны 3 дугаар улирлын байдлаар 21018 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4512 нэгжээр буюу 21.4 хувиар өссөн.

2. Зөрчлийн шинжтэй хүлээн авсан 1450 гомдлоос 828 гомдолд зөрчлийн хэрэг нээж, 487 гомдлыг хялбаршуулсан журмаар шалгаж, 124 гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна. Зөрчлийн шийдвэрлэлтийг авч үзвэл 20322 иргэн, хуулийн этгээдийг 797.406.000 төгрөгөөр, 392 иргэний жолоодох эрхийг хасаж 156.800.000 төгрөгөөр тус тус торгож, 214 иргэнийг шүүхээр баривчлуулсан байна.

3. Тус цагдаагийн газрын алба хаагчдаас энэ оны 3 дугаар улиралд 5 алба хаагч сахилгын арга хэмжээ /офицер 5 / авагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. Сахилга, ёс зүйн зөрчлийн хэлбэрээр авч үзвэл ажлын хариуцлага алдсан 4, ажил тасалсан 1 байна. Шийтгэлийн төрлийг авч үзвэл 4 алба хаагчид сануулах, 1 алба хаагчид албан тушаалын сарын үндсэн цалинг 10-20 хүртэл хувиар бууруулах арга хэмжээ ногдуулсан.

4. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/135 дугаар тушаалаар тус цагдаагийн газрын орон тоог офицер 71, ахлагч 42, гэрээт ахлагч 4, энгийн 2, нийт 119 орон тоотойгоор баталж, энэ оны 3 дугаар улирлын байдлаар офицер 68, ахлагч 45 нийт 4 орон тоо дутуу /Хэсгийн төлөөлөгч 1, хэсгийн байцаагч 1, эрүүлжүүлэх байрны дарга, эмч 1, зохицуулагч 1/ ажиллаж байгаа нь хүний нөөцийн нөхөн хангалт 96.6 хувьтай байна.

5. Алба хаагчдын харилцаа, хандлагыг сайжруулах чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулж буй “Өдөр бүр өчигдрөөс илүү байя” аяныг салбар төлөвлөгөө гаргаж зохион байгуулж байна.

6. Цагдаагийн газрын алба хаагч, удирдлагын хамтын ажиллагааг сайжруулах, алба хаагчдад тулгамдаж буй асуудлыг хөндөж гаргах, түүнийг шийдвэрлэх зорилгоор цагдаагийн газрын дарга “Кофетой өглөө” өглөөний уулзалт, ярилцлагыг хийж, алба хаагчдыг хийж хэрэгжүүлж буй ажлын онцлог, гүйцэтгэж буй үүрэг, хүйсийн ялгаагаар нь 8 хэсэгт хуваарьт оруулан, 7 хоногт 2 удаа уулзалтыг зохион байгуулж байна.

7. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулах журмын хэрэгжилтийг хангах, Цагдаагийн Ерөнхий газраас зохион байгуулж буй “Өдөр бүр өчигдрөөс илүү байя” аяны салбар төлөвлөгөөг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор энэ оны 09 дүгээр сарын 30-ны өдөр байгууллага дээр нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан.

Цаашид анхаарч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2024 онд дэвшүүлсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлж, алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэг, сахилга, дэг журам, удирдлагын манлайллыг дээшлүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, алба хаагчдын ажлын хариуцлагыг өндөржүүлэх.

ХЯНАСАН:
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.БААТАРХҮҮ

ТАЙЛАН БИЧСЭН:
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Г.ГАНЧИМЭГ